



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянгад сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/003НА-СТА-ТТЗ

| | |
|--|---|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2025 он</p> | <p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Н.Ариунтуяа Утас:70432545 Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn</p> |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2025. 03. 25 № 2/129
танай _____ -ны № _____ -т

МЯНГАД СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.БАТХИШИГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мянгад сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянгад сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 25.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4, 14.4.5, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.4.2, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалын 3.4.12, 6.4, 6.7, 7.4.2, 7.5, 7.10, дахь заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны нэгтгэсэн тайланг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй,
- Хоршоо хөгжүүлэх сангаас 2018 онд олгосон зээлдэгчийн мэдээллийг сангийн мэдээллийн программд оруулаагүй зээлийг төлүүлээгүй, зээл олгох тухай төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэргүй, зээлийн гэрээ байгуулаагүй,
- Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд, ОНХС-аас хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдэд дотоод хяналт хэрэгжүүлээгүй,
- Үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Асуудлыг онцолсон хэсэг

Мянгад сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 639,945.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 155,173.3 мянган төгрөгөөр буюу 32.0 хувиар давуулан биелүүлжээ.

Сумын түүхт 100 жилийн ойн хандиваар 419,418.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, Эрдэнэбүрэнний усан цахилгаан станцын нөлөөллийн бүсийн нөхөн төлбөрт 332,640.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг Эрчим хүчний яамнаас хуваарилсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|-------|--|------------------------|------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 738,937.3 | 1,021,146.3 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 386,494.8 | 622,609.4 |
| 33 | АВЛАГА | 245,681.5 | 183,022.6 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 34,395.0 | 125,255.9 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 72,366.0 | 90,258.3 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,600,975.4 | 2,074,578.4 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,600,975.4 | 2,074,578.4 |
| 39200 | Биет хөрөнгө | 1,560,085.4 | 2,033,988.4 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 40,890.0 | 40,590.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,339,912.7 | 3,095,724.7 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 20,913.9 | 1,887.4 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 20,913.9 | 1,887.4 |
| 41300 | Өглөг | 20,913.9 | 1,887.4 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,318,998.8 | 3,093,837.3 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,318,998.8 | 3,093,837.3 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 561,660.1 | 561,660.1 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,371,627.5 | 2,146,466.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 385,711.2 | 385,711.2 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,339,912.7 | 3,095,724.7 |

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,356,144.3 | 4,319,016.6 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 405,140.7 | 624,677.0 |
| 110 | Орлогын албан татвар | 288,987.5 | 486,104.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 305,615.8 | 512,097.1 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -16,628.2 | -25,992.4 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 65,106.1 | 56,863.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 51,047.0 | 81,708.6 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 289,677.2 | 562,428.5 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 289,677.2 | 562,428.5 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,661,326.3 | 3,131,911.0 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,029,936.1 | 3,493,505.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,029,936.1 | 3,493,505.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,821,254.0 | 3,431,608.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 485,487.0 | 784,237.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,792.7 | 97,626.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 43,907.1 | 515,996.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 414,943.1 | 880,833.4 |
| 2105 | Нормативт зардал | 446.0 | 198.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,829.2 | 7,180.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,937.1 | 7,915.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 425,553.9 | 104,648.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 381,357.9 | 1,032,972.9 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,208,682.1 | 61,896.7 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 326,208.1 | 825,511.5 |

| | | | |
|----|---|-----------|-----------|
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 50,673.0 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 326,208.1 | 774,838.5 |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мян.төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2023 оны 12-р сарын 31 | 2024 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 3,145,350.8 | 3,817,625.9 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 405,140.7 | 624,677.0 |
| 110 | Орлогын албан татвар | 288,987.5 | 486,104.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 305,615.8 | 512,097.1 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -16,628.2 | -25,992.4 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 65,106.1 | 56,863.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 51,047.0 | 81,708.6 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 25,077.6 | 21,153.9 |
| 1181 | Газрын төлбөр | 13,061.3 | 12,098.0 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 12,908.2 | 48,456.6 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 51,561.3 | 61,037.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 51,561.3 | 61,037.8 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,688,648.8 | 3,131,911.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,523,917.8 | 2,507,345.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,523,917.8 | 2,507,345.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,295,142.0 | 2,445,448.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 482,284.4 | 779,919.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 60,285.6 | 99,835.9 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 42,799.0 | 593,068.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,394.2 | 23,777.4 |
| 2105 | Нормативт зардал | 502.5 | 553.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,737.3 | 10,231.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,937.1 | 7,924.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 437,541.0 | 36,955.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 243,660.9 | 893,183.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,228,775.8 | 61,896.7 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 621,433.0 | 1,310,280.5 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 371,053.2 | 1,074,015.8 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 371,053.2 | 1,074,015.8 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 371,053.2 | 1,074,015.8 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -371,053.2 | -1,074,015.8 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -54,100.0 | -150.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 54,100.0 | 150.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 196,279.8 | 236,114.6 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 190,215.0 | 386,494.8 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 386,494.8 | 622,609.4 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|------|---------------------------------------|--|-------------------------|
| 1 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,992,790.6 | 1,992,790.6 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,992,790.6 | 1,992,790.6 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 326,208.1 | 326,208.1 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,318,998.8 | 2,318,998.8 |
| 11 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 2,318,998.8 | 2,318,998.8 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,318,998.8 | 2,318,998.8 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 774,838.5 | 774,838.5 |
| 20 | 2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 3,093,837.3 | 3,093,837.3 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|-------------|--|--------------------|-----------------------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,006,976.5 | 2,546,141.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,720,334.0 | 1,638,885.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,658,437.3 | 1,576,988.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 799,889.0 | 779,919.8 |
| 210101 | Үндсэн цалин | 423,415.1 | 413,559.2 |
| 210102 | Нэмэгдэл | 301,285.8 | 286,409.3 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 12,018.0 |
| 210104 | Урамшуулал | 43,508.1 | 38,734.5 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 31,680.0 | 29,198.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 99,986.6 | 99,835.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 67,991.2 | 67,989.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,998.9 | 7,961.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,399.0 | 6,369.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,599.7 | 1,592.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,997.8 | 15,922.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 653,311.4 | 593,068.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 38,204.2 | 30,956.4 |
| 210302 | Түлш, халаалт | 564,301.3 | 517,571.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 50,805.9 | 44,540.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 24,747.3 | 23,777.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,399.2 | 3,426.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,450.5 | 17,450.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,897.6 | 2,900.0 |
| 2105 | Нормативт зардал | 553.7 | 553.7 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 553.7 | 553.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,271.8 | 10,231.6 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 317.0 | 317.0 |
| 210604 | Урсгал засвар | 9,954.8 | 9,914.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,924.1 | 7,924.1 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,924.1 | 7,924.1 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 37,030.2 | 36,955.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,853.2 | 34,853.2 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 346.0 | 346.0 |

| | | | |
|-------------|---|--------------------|--------------------|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300.0 | 225.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 34.0 | 34.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,189.5 | 1,189.5 |
| 210807 | Газрын төлбөр | 307.5 | 307.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,723.2 | 24,723.2 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,803.4 | 21,803.4 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,919.8 | 2,919.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 61,896.7 | 61,896.7 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 61,896.7 | 61,896.7 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 27,620.7 | 27,620.7 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 32,364.0 | 32,364.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,912.0 | 1,912.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,206,642.5 | 907,105.8 |
| 220001 | Барилга байгууламж | 344,745.9 | 207,409.6 |
| 221001 | Их засвар | 507,628.6 | 452,548.6 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 199,831.0 | 162,581.1 |
| 223001 | Бусад хөрөнгө | 154,437.0 | 84,566.6 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 80,000.0 | 150.0 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 80,000.0 | 150.0 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,006,976.5 | 2,498,653.9 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,565,163.1 | 2,451,625.1 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,777,779.3 | 1,664,241.3 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 787,383.8 | 787,383.8 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 441,813.4 | 47,028.8 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 605.0 | 1,259.5 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 80,000.0 | 45,769.3 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 361,208.4 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 206,895.1 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 159,407.6 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2 | 2 |
| 610001 | Төсвийн байгууллага | 2 | 2 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 31 | 31 |
| 620001 | Удирдах ажилтан | 9 | 9 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13 | 13 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 4 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 31 | 31 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 11 | 11 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 8 | 8 |
| 650010 | Гэрээт ажилтан | 4 | 4 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 8 | 8 |

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 19,780.8 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил² илэрснээс аудитын явцад залруулга хийгдээгүй.

Залруулагдаагүй нийт 19,780.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс “бага” боловч шинж чанарын хувьд материаллаг тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 19,780.8 мянган төгрөгийн зөрчил³ илэрснээс 4,870.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 15,000.0 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Зээл, зээлийн хүүгийн төлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн мэдээллийн программд 2018 онд сангаас олгосон зээлдэгчийн мэдээллийг оруулаагүй, зээл, зээлийн хүүг төлүүлээгүй, зээл олгох тухай төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэргүй, Засаг даргын зээл олгох захирамжгүй, зээлийн гэрээ байгуулаагүй, зарим зээлдэгчийн мэдээлэл зөрүүтэй, төлөгдөөгүй зээл, зээлийн хүүгийн 4,780.8 мянган төгрөгийн үлдэгдлийг сангийн программд бүрэн төлөгдсөнөөр хаасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;", Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.12-д "Сумын хоршоо жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Монгол банкны зээлийн мэдээллийн санд илгээх мэдээллийг аймгийн хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэнд илгээж хянуулна;", 6.4-д "Энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан хоршооны боловсруулсан төсөл дараах нийтлэг шалгуурыг хангасан байна:", 6.7-д "Төсөл сонгон шалгаруулах хорооны шийдвэрийг тухайн сумын Засаг дарга хүлээн авч баталгаажуулан, эрэмбэлсэн жагсаалтын дагуу санхүүжүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Сангийн дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт*

5.2 Зөвлөмж

5.2.1 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ЗДТГ-т шим ус ОНӨААТҮГ-аас үнэ төлбөргүйгээр шилжүүлсэн 2 ширхэг ОО-ийг орлогод аваагүй данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-т "бүх орлого"; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: *Хөрөнгийг 2025 оны улиралд багтаан данс бүртгэлд тусгах*

¹ Мэдээллийг тусгаагүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2.2 ОНХС болон Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх сангийн журамд зааснаар "Хяналтын зөвлөл" сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах," Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 361 дүгээр тушаалаар "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 7.4-д "Хяналтын зөвлөл сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавихдаа дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:", 7.4.2-д "сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, ИТХ-ын даргад хүргүүлнэ;" 7.5-д "Сумын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн аймгийн Засаг даргад хүргүүлнэ", 7.10-д "Сангийн зээлдэгч нь төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлж, зээл, зээлийн хүүгийн төлбөрийг гэрээний үүргийн дагуу төлж, төслийн талаарх тайланг жилд нэг удаа сумын иргэд, олон нийтэд тайлагнана. Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4-д "Сум, дүүргийн Засаг даргын чиг үүрэг: 3.4.3.Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих," 3.4.4-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хууль, аргачлал, журамд нийцүүлэн хийх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих," Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.4.2-д "өөрийн болон доод шатны Засаг даргын ажлын алба, харьяа байгууллага, аж ахуйн нэгжид мөрдөх", "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг"-ыг аймаг, нийслэлийн Засаг дарга, 1.5-д "Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө. 4.1.5-д "өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт," гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сан, ОНХС-ийн журамд заасны дагуу дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 07 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

| Аудитад хамрагдсан шалгагдагч байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|--|-------------|----------------|---------------|---------------|-----------------|-----|----------|----------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Мянгад сумын ТТЗ | 3 | 19,780.7 | 1 | 4,780.7 | | | 2 | 15,000.0 | - | - | - | - |
| Дүн | 3 | 19780.7 | 1 | 4780.7 | - | - | 2 | 15000.0 | - | - | - | - |

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

| Аудитад хамрагдсан шалгагдагч байгууллагын нэр | Аудитад хамрагдвал зохих | Хамрагдсан | Байгууллагын тоо | | Аудитын санал дүгнэлтийн төрөл | | | |
|--|--------------------------|------------|------------------------|--------------------|--------------------------------|-----------------|----------|----------------------------|
| | | | Гүйцэтгэсэн | | үүнээс | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Зөрчилгүй | Хязгаар лалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| ИТХ | 1 | 1 | | 1 | | | | |
| ЗДТГ | 1 | 1 | 1 | | | 1 | | |
| Хоршоо хөгжүүлэх сан | 1 | 1 | | 1 | | | | |
| ОНХС | 1 | 1 | | 1 | | | | |
| НИЙТ | 4 | 4 | 1 | 3 | - | 1 | - | - |